



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/178

Ховд

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.1, 27¹.1.6, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/178 дугаартай “Шуурхай штаб байгуулах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн Онцгой комиссын шуурхай штабыг байгуулсугай.

2. Аймгийн Онцгой комиссын шуурхай штабыг нэгдүгээр, үерийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үүссэн нөхцөл байдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж танилцах, хяналт тавих, аймгийн Засаг дарга болон аймгийн Онцгой комиссыг мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, Шуурхай штабын дарга, хурандаа (Б.Алтанбадралт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД



82100011 1024
Zah A/422 Ba

Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 12-ны өдрийн
А/422 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт



ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга : Б.Алтанбадралт (Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
- Орлогч дарга: Г.Нэргүй (Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын орлогч, дэд хурандаа)
- Нарийн бичиг: Д.Энхбаатар (Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахлах дэслэгч)
- Гишүүд:
- Ц.Мягмарсүрэн (Эрүүл мэндийн газрын дарга)
 - А.Энхзаяа (Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)
 - Г.Цоодол (Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)
 - Б.Төгөлдөр (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
 - Ч.Эрдэнэбат (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Ц.Цогтбаяр (Жаргалант сумын Засаг дарга бөгөөд Ховд хотын захирагч)
 - Л.Ариунаа (Статистикийн хэлтсийн дарга)
 - Б.Одонпүрэв (Улаан загалмайн хорооны дарга)
- Сумдын Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нар
- Сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нар

-оОо-

Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 12-ны өдрийн
А/422 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

ҮЕРИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ
ҮНЭЛГЭЭ ХИЙХ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Ц.Дэлгэр (Ус цаг уур орчны шинжилгээний газрын
Технологийн хэлтсийн дарга)
- Гишүүд: Б.Пүрэвсүрэн (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын Хүнс тэжээлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)
- А.Цэен-Ойдов (Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын Орчны бохирдол, гамшгийн
асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Э.Цогтсайхан (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Газрын удирдлагын
хэлтсийн дарга)
- Х.Мөнхзолбоо (Ховд аймаг дахь Статистикийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: С.Цогзаяа (Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой
байдлын газрын Гамшгийн эрсдэлийн
удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн, ахлах дэслэгч)

-оОо-